



ХАСБАНКНЫ ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Улаанбаатар хот, Монгол Улс

Оршил

ХасБанк (цаашид “**Банк**” гэх)-ны Засаглалын Кодекс (цаашид “**Кодекс**” гэх) нь:

- А. Хариуцлагатай, найдаж болохуйц бөгөөд үнэт зүйлд тулгуурласан гүйцэтгэлийн удирдлага;
- В. Хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэсэн, Банкны болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллах гүйцэтгэх удирдлагын үр нөлөөтэй хяналт; болон
- С. Хүчирхэг эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын систем хосолсон тохиромжит мэдээлэл гаргах өгөх тогтолцоогоор дамжуулан Банкны засаглалын бүтцийг чадавхжуулах буюу саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Компанийн кодекс, дүрэм, журмуудыг тогтмол хугацаанд баталж, даган мөрдөж, нэмэлт өөрчлөлт оруулснаар Компани сайн засаглалыг төгөлдөржүүлэх үүрэг амлалтаа бататгах юм.

Банкны эрх бүхий этгээд болон ажилтнууд нь Кодексийг хамтын үүрэг хариуцлага гэдгийг ухамсарлаж байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

Нэгдүгээр хэсэг. Засаглалын үүрэг хариуцлага

1. Тодорхойлолт, зарчим

Банк нь компанийн засаглалыг хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэх зорилготой Банкны хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/, гүйцэтгэх удирдлага хоорондын удирдлага, хяналтын цогц бүтэц болон үйл ажиллагаа гэж тодорхойлж байна. Түүнчлэн, компанийн засаглалыг Банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжлийн чухал бүрэлдэхүүн гэж үзнэ.

Кодекс нь Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны 2022 онд баталсан Компанийн Засаглалын Кодекс болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагад үндэслэн Банкны засаглалын харилцааны хүрээг тодорхойлно.

Банкны засаглалын харилцааны хүрээ нь дараах зарчимд үндэслэнэ:

- А. Итгэж болохуйц байдал: Банкны бүхий л хүмүүс, тэдгээрийн нэгдэл, ялангуяа ТУЗ, удирдлага нь өөрийн үйлдэл, шийдвэр, гүйцэтгэлийн хувьд бүхий л оролцогч талуудын өмнө нарийн тодорхойлсон албан үүрэг, үр нөлөөтэй хяналтын механизмаар дамжуулан хариуцлага хүлээнэ.
- В. Шударга байдал: Банк нь бүхий л хувьцаа эзэмшигчийг эрх тэгш, шударгаар хүлээн авч үзэх бөгөөд жижиг буюу гадаад хувьцаа эзэмшигч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална. Банк хувьцаа эзэмшигчийг Банктай холбоотой аливаа харилцаанд, тодруулбал, шийдвэр гаргах, ногдол ашиг шударгаар хуваарилахад эрх тэгш оролцох, ялгаварлан гадуурхалтаас ангид байлгана.
- С. Ил тод байдал: Банк нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэл, засаглалын

бүтэц болон бусад голлох асуудлын талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа журмын дагуу бүхий л оролцогч талуудад тухай бүр үнэн зөв, алдаагүй мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

- D. Хариуцлага: Банк нь бүхий л оролцогч талууд, тодруулбал, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, харилцагчид болон олон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзэж хариуцлагатай шийдвэр гаргаж үйл ажиллагаа явуулна. Хариуцлага нь зөв зүйтэй шийдвэр гаргах, стратегийн үр нөлөөтэй хэрэгжилт, эрх бүхий байгууллагын тогтоосон журамд бүрэн нийцэж ажиллах, эрсдэлээс хамгаалах буюу боломжийг бүрдүүлэх идэвхтэй удирдлагын тогтолцоогоор дамжуулан Банкны урт хугацааны үр ашигтай, тогтвортой байдлыг хамгаалахтай холбоотой юм;
- E. Ес зүй болон нэгдмэл байдал: Банк өөрийн бүхий л үйл ажиллагаа болон харилцаанд ёс зүйн өндөр стандарт, нэгдмэл байдлыг эрхэмлэнэ. Үүнд тогтоосон ёс зүйн хэм хэмжээг сахих, харилцаанд үнэнч, ил тод байдлыг хадгалах, байгууллагын бүхий л түвшинд нэгдмэл байдлын соёлыг түгээх болон албан тушаалын байдлаа урвуулан ашиглахын эсрэг тууштай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг хамаарах юм;
- F. Эрсдэлийн удирдлага: Банк нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэл, нэр хүндэд нөлөөлөхүйц эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үр нөлөөтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох буюу хадгалж ажиллана. Банкны хөрөнгө, оролцогч талын эрх, хууль ёсны ашиг сонирхол, урт хугацааны тогтвортой байдлыг хамгаалах үүднээс үр нөлөөтэй дотоод хяналтын болон хянан нийцүүлэх журмын хэрэгжилтийг Банк хангуулах үүрэг хүлээнэ.

Банк, түүний бүхий л ажилтнууд нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг даган мөрдөх бөгөөд энэхүү Кодекс, холбогдох бусад баримт бичигт тодорхойлсон бизнесийн ёс зүйн стандартыг сахих үүрэгтэй.

2. Компанийн дотоод бичиг хэрэг

Энэхүү Кодекс нь зарчимд үндэслэсэн. Засаглалын бүтэц, үйл ажиллагааг Банкны Дүрэм болон бусад журмаар нарийвчлан зохицуулна. Банкны дотоод баримт бичгүүд нь хууль буюу зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах бөгөөд Компанийн тухай хууль болон компанийн засаглалын сайн туршлагаас голлох зохицуулалтыг авч хэрэглэсэн.

3. Засаглалын ерөнхий бүтэц

Банк нь дараах эрх барих байгууллага болон бусад эрх бүхий этгээдтэй байна:

- A. Хувьцаа эзэмшигчдийн хурал (“ХЭХ”) нь хувьцаа эзэмшигчид Банкны засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох боломж бүхий эрх барих дээд байгууллага болно;
- B. ТУЗ нь Банкны стратегийг хэрэгжүүлэх, удирдлагыг чиглүүлэх үүргийг хүлээсэн. ТУЗ нь аудитын, эрсдэлийн удирдлагын, нэр дэвшүүлэх болон засаглал, цалин урамшууллын хороог заавал байгуулж ажиллана. Түүнчлэн, ТУЗ нь шаардлагатай бусад байнгын болон түр хороог байгуулах эрхтэй байна;
/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

- С. Гүйцэтгэх захирал (“ГЗ”) болон түүний баг нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн тавьсан стратегийг хэрэгжүүлнэ;
- Д. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь эрх бүхий этгээд хоорондын харилцаанд дотоод, гадаад журмыг мөрдүүлэх болон ТУЗ-ийн гишүүдийн зөвлөхөөр ажиллана;
- Е. Дотоод аудитор нь Банкны бизнесийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих журмыг баталж мөрдүүлнэ. Дотоод аудитор нь Аудитын хороо (дор тодорхойлсон)-гоор дамжуулан ТУЗ-д, удирдлага зохион байгуулалтын хувьд ГЗ-д ажлаа тайлагнана.

4. Компанийн засаглалын бодлого журам, туршлагад нийцүүлэх буюу даган мөрдөх

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Банкны засаглалын бодлого журмын боловсруулалт, хянан нийцүүлэлт болон тодорхой хугацааны давтамжтайгаар хянах ажлыг хариуцна.

Энэ нь үнэлгээ хийх, салбарын стандартын жишиг тогтоох судалгаа, засаглалын тэргүүлэх чиглэлд үндэслэн сайжруулах болон зохицуулалтгүй хэсгийг тодорхойлох юм. ТУЗ нь тодорхойлсон хэсгүүдийн ач холбогдол, байгууллагын засаглалын үр нөлөөтэй байдалд үзүүлэх нөлөөг үндэслэн эрэмбэлнэ. Энэ дагуу ТУЗ нь анхаарал хандуулсан зохицуулалтгүй хэсгүүдийг зохицуулж засаглалыг чадавхжуулна. Үүнд анхаарал хандуулах хэсгийн хувьд хэрэгжүүлэх голлох арга хэмжээ, санаачилга, үүрэг бүхий этгээдийг тогтоох, амжилттай хэрэгжүүлэх бодит төлөвлөгөөг гаргах зэрэг хамаарах юм.

Хоёрдугаар хэсэг. ТУЗ-ийн сайн туршлага

Банк нь сонор соргог, мэргэжлийн бөгөөд хараат бус ТУЗ нь сайн засаглалд нэн чухал гэж үздэг. Банк чадварлаг удирдлага болон үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн орчныг өөрчлөх боломжгүй. Хэдий тийм боловч, хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийн төлөө удирдлагыг чиглүүлж, хянаж Банкны гүйцэтгэлд нөлөөлөх боломжтой юм. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалтан засаглалд мөн чухал үүрэгтэй. Эрх бүхий этгээдүүдийн хоорондын үр дүнтэй харилцаа болон эрх мэдлийг тодорхой зааглах нь зохистой засаглалын түлхүүр юм.

1. ТУЗ-ийн түвшинд

- А. Эрх хэмжээ. ТУЗ-ийн эрх хэмжээний хүрээг холбогдох хуульд нийцүүлэн Банкны Дүрэмд заасан.
- В. Гишүүдийн тоо. ТУЗ нь ЗЦУХ-ны саналын үндсэн дээр гишүүдийн тооны зохистой тоог санал болгоно. ТУЗ-ийн гишүүдийн тоог Дүрэмд заана. Шаардлагатай мэргэшил, ур чадвар нь гишүүдийн тоог тогтооход голлох үзүүлэлт болно.
/Энэ заалтад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- С. Томилгоо, хугацаа, албан үүргээс чөлөөлөх. Гишүүдийг хоёр жилийн хугацаагаар томилно. Хугацааны хязгаарлалт тогтоох нь Банк болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцнэ гэж ТУЗ үзэхгүй. Банк болон банкны салбарын мэдлэг бүхий туршлагатай гишүүд нь зөв зүйтэй чиглэл өгч ажиллах тулгуур юм.
- Д. Бүрэлдэхүүн, хараат бус байдал. Банк олон төрлийн ур чадвар, мэдлэг, туршлага,

жижиг хувьцаа эзэмшигчид буюу бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий алсан хараатай, бүтээлч бөгөөд үр дүнтэй ажиллах ТУЗ-ийг бүрдүүлнэ.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн, эрх хэмжээ болон ур чадвар нь Банкны чиглэл, стратегийн хэрэгжилтийг хянахад тохирсон байна. Гишүүд тус бүр нь ТУЗ-ийн гишүүний албан үүргийг хэрэгжүүлэх, Банк, хувьцаа эзэмшигчдийн урт хугацаан ашиг сонирхлын төлөө ажиллах ТУЗ-ийн чадамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай туршлага, мэдлэг, ур чадвартай байна. ТУЗ нь Банкны үндсэн үйл ажиллагаа, салбар болон газар зүйн бүсийг хамарсан өргөн хүрээний ажлын туршлагатай байна.

Гишүүд нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Банкны хэрэгцээ шаардлагад үндэслэн Нэр дэвшүүлэх хороо /дор тодорхойлсон/-оос тогтоосон аливаа нэмэлт шаардлагад нийцсэн байна. ТУЗ нь Гишүүдийн боловсрол мэргэшлийн талаарх бүрэн бөгөөд багц мэдээллийг Нэр дэвшүүлэх хороо (доор тодорхойлсон)-ноос гаргасан зөвлөмжийн дагуу хоёр жил тутам хянана.

Хараат бус гишүүдийн үндсэн үүрэг нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах юм. Үүнийг баталгаажуулах үүднээс ТУЗ-ийн гишүүдээс хамгийн багадаа 1/3 нь хараат бус гишүүн байна.

Банк нь ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг эрмэлзэнэ. Банк нь СЗХ-ны Компанийн Засаглалын Кодекст нийцүүлэн хүйсийн төлөөлөл хамгийн багадаа 30 хувь байхад анхаарч ажиллана. Хүйсийн тэнцвэртэй байдлыг зөвхөн ТУЗ-өөр хязгаарлалгүй компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудын хэмжээнд хадгалахыг зорино. Банк хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалсан ажлын орчныг бүрдүүлэхийн учир холбогдлыг бүхий л түвшинд хүлээн зөвшөөрсөн.

/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

Е. Бүтэц, Хороод. Банк нь ТУЗ-ийн дараах хороодыг байгуулсан:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Засаглал, цалин урамшууллын хороо (“ЗЦУХ”)
- Аудитын хороо (“Аудитын хороо”);
- Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”);

Бусад хороодыг ТУЗ шаардлагатай гэж үзвэл байгуулж болно. Бүх хороод нь эрх хэмжээ, бүрэлдэхүүн, ажлын горим, гишүүдийн эрх, үүргийг тусгасан журамтай байна. Хуралдаан болгоны дараа хороо тайлангаа ТУЗ-д хүргүүлнэ.

Аудитын хорооны дарга нь хараат бус байх болон хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс ТУЗ-ийн Даргаар нэгэн зэрэг ажиллахгүй.

/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

Ф. Ажлын горим. ТУЗ нь албан үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс томилогдсон цагаас эхлэн тогтсон хуваарийн дагуу хуралдана. ТУЗ жилд 4 /дөрөв/-өөс доошгүй удаа хуралдана.

ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах ажиллагааг өөрийн журмаар тодорхойлно. Гишүүдэд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга товч боловч багц мэдээллийг цаг тухайд гаргаж өгнө.

ТУЗ нь хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хадгалах ба шийдвэр, санал хураалтын дүнг санал өгсөн гишүүн бүрээр дурдаж ТУЗ-ийн Дарга, Нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

- Г. Өөрийн үнэлгээ. ТУЗ өөрийн үнэлгээг жил бүр хийнэ. Үнэлгээг ТУЗ-ийн Дарга хийх бөгөөд тайланг ТУЗ-өөр хэлэлцүүлнэ. ТУЗ-ийн Дарга үнэлгээнд хараат бус зөвлөхийг урьж оролцуулж болно.
- Н. Сургалт, зөвлөхөөс туслалцаа авах. Банк шинэ гишүүдэд албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өөрийн үйл ажиллагаатай холбоотой чиглүүлэх сургалтыг явуулна. Банк Нэр дэвшүүлэх хорооноос зөвлөмж болгож ТУЗ-өөс баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу гишүүдийг сургалтад хамруулна. ТУЗ нь өөрийн шийдвэрээр Банкны зардлаар холбогдох журмын дагуу гаднаас мэргэжлийн туслалцаа авна.
/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/
- И. Цалин урамшуулал. ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын бус гишүүдийн цалин урамшуулал өрсөлдөхүйц бөгөөд албан үүрэгт тохирсон байна. ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гишүүд нь Банкны албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор авч байгаа цалин урамшууллаас өөр цалин, урамшуулал авахгүй ЗЦУХ гишүүдийн цалинг тодорхой хугацаанд хянана. Бүх гишүүд Банктай гэрээ байгуулна.
/Энэ заалтад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- Ж. Албан үүрэг, хариуцлага. Гишүүд холбогдох бүхий мэдээлэлд үндэслэн албан үүргээ үнэнчээр, зохих ёсоор Банк, хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийн төлөө гүйцэтгэх буюу тодорхой нэг эсхүл бүлэг хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийн төлөө гүйцэтгэхгүй. Гишүүд ТУЗ-ийн болон бусад хороодын хуралдаанд биечлэн оролцоно.

ТУЗ гишүүд бусад компанид эрх бүхий этгээдийн хувиар ажиллаж болох эсэхийг шийдвэрлэнэ. Ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй тохиолдолд Банк гишүүдийг бусад компанийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллахыг хориглохгүй. Гишүүд нь өөрийн бусад үүрэг, хариуцлага албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах буюу зөрчилдөхгүй байхыг хариуцна.

Гишүүд албан үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа буюу чөлөөлөгдсөний дараа Банкны нууц, дотоод мэдээллийг задруулах, ашиглахгүй.

Гишүүд Банктай ашиг сонирхлын зөрчил үүсгэх үйлдлээс зайлсхийнэ. Ашиг сонирхлын зөрчил гарвал гишүүд ашиг сонирхлын зөрчлийн талаар бусад гишүүдэд мэдэгдэх бөгөөд тухайн асуудлаар зөвлөлдөх болон санал өгөхөөс зайлсхийнэ.

2. Гүйцэтгэх удирдлагын түвшинд

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулахад ГЗ-ын манлайлал чухал шаардлагатайг Банк ойлгож байна. Түүнчлэн, банкны үйл ажиллагаа явуулахад учрах сорилт, нарийн төвөгтэй байдлыг хүлээн зөвшөөрч багийн ажиллагаанд найдаж байна.

- А. Эрх хэмжээ. ГЗ нь банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж түүний зорилго, зорилт, стратегийг хэрэгжүүлнэ.
- В. Томилгоо, хугацаа, үүрэгт ажлаас чөлөөлөх. ТУЗ нь Гүйцэтгэх захирлыг Нэр

дэвшүүлэх хорооны санал болгосноор томилно.

ТУЗ ГЗ-ын үүрэгт ажлаас чөлөөлж болно. Үүрэгт ажлаас чөлөөлөхөд ТУЗ-д худал мэдээлэл өгөх, албан үүргээ гүйцэтгэхээс санаатайгаар зайлсхийх эсхүл гэмт хэрэг үйлдсэн зэрэг үндэслэл хамаарна.

/Энэ заалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ-ийн R-2025-21 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

- С. Залгамж төлөвлөгөө. ТУЗ гүйцэтгэх удирдлага түр буюу чөлөөлөгдсөн байх тохиолдолд хэрэгжүүлэх залгамж төлөвлөгөөг баталж жил бүр хянаж байна. ГЗ нь ТУЗ-д Банкны гүйцэтгэх удирдлагын багт ажиллах тохиромжтой хувь хүмүүсийн нэрсийг гаргаж өгнө .
- Д. Цалин урамшуулал, үнэлгээ. ГЗ-ын цалин урамшууллын хэмжээг ТУЗ тогтооно. Цалин урамшуулал нь тогтмол болон хувьсах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хувьсах бүрэлдэхүүн нь Банкны урт хугацааны хөгжил болон хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэнтэй гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй холбоотой юм.
- Е. Албан үүрэг, хариуцлага. ГЗ болон гүйцэтгэх удирдлагын бусад гишүүд холбогдох бүхий мэдээлэлд үндэслэн албан үүргээ үнэнчээр, зохих ёсоор Банк, хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийн төлөө гүйцэтгэх буюу тодорхой нэг эсхүл бүлэг хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийн төлөө гүйцэтгэхгүй.

ГЗ болон гүйцэтгэх удирдлагын бусад гишүүд өөр хоорондоо болон Банктай ашиг сонирхлын зөрчил үүсгэх үйлдлээс зайлсхийнэ. Ашиг сонирхлын зөрчил гарвал эрх бүхий этгээд ашиг сонирхлын зөрчлийн талаар ТУЗ-д мэдэгдэх бөгөөд тухайн асуудлаар зөвлөлдөх болон санал өгөхөөс зайлсхийнэ.

3. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа, ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үүрэг

Дүрэмд зааснаар ГЗ эсхүл бусад гүйцэтгэх удирдлагын албан тушаалтанд чиглэл өгөх, мэдээлэл хүргүүлэх эрх хэмжээ нь зөвхөн ТУЗ-ийн шийдвэр байна. ТУЗ-ийн гишүүдийн хоорондын болон тэдгээрийн гүйцэтгэх удирдлагатай харилцах харилцааг ГЗ-аар дамжуулах буюу аль аль талд саадгүй явуулахыг чухалчлах.

Банкны ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллана. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь эрх бүхий этгээдүүдийг дотоод, гадаад журмыг даган мөрдүүлэх, тэдгээрийн хоорондын харилцааг Банкны дүрэм, бусад дотоод журмын дагуу саадгүй явуулахад шаардлагатай мэргэшил, ур чадварыг эзэмшсэн байх ба голлох албан тушаалтнуудад засаглалын шинэ мэдээллээр хангана.

Гуравдугаар хэсэг. Хувьцаа эзэмшигчдийн эрх

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Банк нь Компанийн тухай хуульд зааснаар ХЭХ-ын бэлтгэл, зохион байгуулах болон шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой нарийвчилсан тайлбар бүхий дотоод журамтай.

- А. Бэлтгэл. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч бүр ХЭХ-д оролцох буюу санал өгөх эрхтэй бөгөөд ХЭХ-аар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдэгдэл, хэлэлцэл асуудлын

жагсаалт, үнэн зөв, шийдвэр гаргахад хангалттай бүхий л мэдээл тухай бүр буюу өмнө нь авах эрхтэй. Банкны гүйцэтгэх удирдлагын албан тушаалтан энэхүү асуудлыг хариуцах бөгөөд ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар дамжуулан хэрэгжүүлнэ.

Банк нь Компанийн тухай хуульд зааснаар ХЭХ-аар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах санал гаргах болон ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх шударга, үр нөлөөтэй журмыг даган мөрддөг. ХЭХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалтыг ТУЗ нэгэнт баталсан бол өөрчлөхгүй.

- В. ХЭХ-ыг зохион байгуулах. Банк нь хувьцаа эзэмшигчдийг ХЭХ-д оролцож, хэлэлцсэн асуудлаар санал өгүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авна.

ХЭХ-ыг зохион байгуулах газар нь хувьцаа эзэмшигч нарт хүрэлцэн очих боломжтой байна. Бүртгэлийн ажиллагаа нь аль болох амар хялбар, хурдан байж ХЭХ-д оролцоход төвөг учруулахгүй байна.

Банкны гүйцэтгэх удирдлагын албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч ХЭХ-д биечлэн оролцох боломжгүй тохиолдолд тэдгээр нь санал өгөхөд туслалцаа үзүүлнэ. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч нараас итгэмжлэл авах бөгөөд хувьцаа эзэмшигчид нь итгэмжлэл олгосны үндсэн дээр хэлэлцэх асуудлуудад санал өгөх зааварчилгааг өгөх боломжтой болно.

Банк нь ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын албан тушаалтан болон Хөндлөнгийн аудиторыг ХЭХ-ын үед байлцуулж асуултад хариулах боломжоор ханган. Хувьцаа эзэмшигч бүр хурлын үеэр хэлэлцэх асуудалд орсон асуудалтай холбоотой асуулт асуух эрхтэй. ХЭХ даргалагч нь хурлыг мэргэжлийн, шударгаар үр дүнтэй удирдан явуулна.

Банк нь өөрийн Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон бусад журамд ХЭХ-д жижиг хувьцаа эзэмшигч нар санал өгөхөд шударга бус явдлаас хамгаалах үр дүнтэй механизмтай. ХЭХ-ын санал тоолох ажиллагааг ил тод явуулах буюу санал хураалтын үр дүнд шударга бусаар нөлөөлөх боломжийг хязгаарлана.

- С. Санал хураалтын үр дүн. Санал хураалтын үр дүн болон хамааралтай материалыг холбогдох хууль болон журамд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчид ил болгоно.

2. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах

Жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах зарчим нь хувьцаа эзэмшигчид адил тэгш хандах, санал хураалтад жижиг хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын эрхийг онцгойлон харгалзаж үзэх, Монголбанкны журмын дагуу ТУЗ-д хэд хэдэн хараат бус гишүүнийг томилох, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдээллийг тухай бүр авах эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилна. Бүх хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхдээ мэдээлэлтэй байж шийдвэр гаргахад шаардлагатай буюу хангалттай мэдээллээр хангана.

Бүх хувьцаа эзэмшигчид адил тэгш хандахыг Банк хариуцна. Томоохон хувьцаа эзэмшигч нар үлэмж ашигтай хэлцлээс татгалзана. Шинээр үнэт цаас гаргах, худалдах, нэгдэх буюу нийлэх тохиолдолд хувьцаа эзэмшигч нарт шударга, адил тэгш хандана.

3. Холбогдох этгээдтэй хийх хэлцэл

Холбогдох этгээдтэй хийх хэлцлээ аль болох зайлсхийх ба хийх тохиолдолд зах зээлийн нөхцөлөөр, шударга байдлыг хангаж аливаа давуу байдал олгох явдлаас сэргийлнэ. Эдгээр хэлцлийг холбогдох хууль тогтоомжид зааснаар ил болгоно. Хэлцэл хийх зөвшөөрөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. Банк нь холбогдох этгээдтэй хийх хэлцлийг зохицуулах дотоод журмыг мөрдүүлж тэдгээр хэлцлийг энэхүү Кодекст нийцүүлэн байгуулахыг хариуцна.

4. Ногдол ашгийн бодлого журам

Банк албан ёсоор баталсан сайтар тодорхойлсон, бичмэл бодлого журмыг баримтална. Энэхүү бодлого журам ногдол ашгийн хэмжээг зохистой хэмжээнд тогтоох тодорхой аргыг агуулсан байна. Бодлого журам нь ногдол ашгийг шууд, үр дүнтэй төлөх журам, зарласан ногдол ашгийг бүхэлд нь төлөх баталгаа юм.

Дөрөвдүгээр хэсэг. Мэдээллийг олон нийтэд ил болгох, ил тод байдал

Тухай бүр зөв мэдээллийг ил тод болгох Банкны засаглалын гол зарчим юм.

1. Ил тод болгох бодлого, журам болон зохицуулалт

Холбогдох журамд зааснаар Банк нь Банкны санхүүгийн гүйцэтгэл, хувьцаа эзэмшил, засаглалын бүтэцтэй холбоотой бүхий л мэдээллийг ил болгож танилцахад амар хялбар боломжийг бүрдүүлнэ. ТУЗ нь мэдээллийг ил болгох дотоод журмыг батлах ба Банкны вэбсайтад олон нийтэл нээлттэй байршуулна. Банк нь холбогдох хууль тогтоомжид зааснаар өөрийн засаглалын талаарх тухайлсан хэсэг бүхий жилийн тайланг хэвлүүлэх бөгөөд бусад тайланг бэлтгэнэ.

Банк нь мэдээллийг ил болгох дотоод журамд зааснаар хувийн мэдээллийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Банкны ажилтан, ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчид олж авсан аливаа дотоод мэдээллийг өөрийн эрх ашгийн төлөө ашиглах буюу бусад задруулж болохгүй.

2. Санхүү тайлагнал

Банк нь өөрийн санхүүгийн тайланг Олон Улсын Санхүүгийн Тайлагналын Стандартад нийцүүлэн хөтөлж бэлтгэх бөгөөд эрх бүхий байгууллагад хүргүүлэх тайлан, жилийн тайлан болон вэбсайтад байршуулж тогтмол олон нийтэд ил болгоно.

3. Дотоод аудит болон Хяналт

- А. Дотоод аудитор. Банк нь түүний санхүү болон үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавих үүрэг бүхий Дотоод аудитортай байна. Дотоод аудитораар ажил хэргийн өндөр нэр хүндтэй хувь хүнийг томилох бөгөөд чиг үүргийн хувьд Аудитын хороонд, удирдлага зохион байгуулалтын хувьд Гүйцэтгэх захиралд ажлаа тайлагнана. Дотоод аудиторын эрх хэмжээ, зохион байгуулалт, ажлын горим болон бусад холбогдох асуудлыг өөрийн журмаар зохицуулна.
- В. Аудитын хороо. Аудитын хороо нь санхүүгийн тайлан болон дотоод, гадаад аудит гэсэн голлох хоёр хэсэгт төвлөрч ажиллана. Хороог өөрийн санхүүгийн мэдлэг, чадвараар хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус гишүүн даргалах ба тэрхүү шалгуурт нийцсэн гүйцэтгэх удирдлагын бус гишүүдээс бүрдүүлнэ. Хорооны эрх хэмжээ, бүрэлдэхүүн,

ажлын горим болон бусад холбогдох асуудлыг өөрийн дүрмээр зохицуулна.

4. Хөндлөнгийн аудит

Хөндлөнгийн аудит нь Банкны санхүүгийн тайланд аудит хийнэ. Хөндлөнгийн аудитор нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус аудитын фирм байх бөгөөд хараат бус гэдэгт Банк, түүний удирдлага, ТУЗ-ийн гишүүд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс хараат бус байхыг ойлгоно. Банк нь журамд нийцүүлэн тогтмол хугацаанд хөндлөнгийн аудиторыг өөрчлөхийг хариуцна.

Аудиторын ажлын хөлсийг хувьцаа эзэмшигч нар ил болгоно. Хөндлөнгийн аудиторыг Дүрэмд зааснаар сонгон шалгаруулна.

Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож аудитын явц болон холбогдох асуудлаар хувьцаа эзэмшигч нарт мэдээлэл өгнө.

5. Хувьцаа эзэмшлийн бүтэц

Банк нь саналын эрхтэй хувьцааны тав буюу түүнээс дээш хувийн эцсийн өмчлөгчийг нийтэд ил болгох асуудлыг хариуцна.